



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/410

Чингис хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Монгол Улсын Засгийн газрын 259 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 06 дугаар албан даалгавар, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41, 43, 46, 51 дүгээр тушаал, аймгийн онцгой комиссын 25 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгасугай.

2. 2021-2022 оны хичээлийн жил эхлэж байгаатай холбогдуулан “Коронавируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөгдөх түр журам”, “Коронавируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөгдөх түр журам” –ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар (С.Мөнхцэцэг), бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгож, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ)-т тус тус даалгасугай.

3. Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан Ковид-19 халдварт өвчний ойрын хавьтал болсон багш ажилчид, хүүхдүүдийн шинжилгээг зохион байгуулж холбогдох зардлыг шийдвэрлэхийг сумдын Засаг дарга, тосгодын Захирагч нарт үүрэг болгосугай.

4. Коронавируст халдвар Ковид-19 халдварт өвчний тохиолдол нэмэгдэж байгаатай холбогдуулан сумдын эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилтнуудыг аймгийн нэгдсэн эмнэлэгт ажиллах хуваарийг гаргаж батлуулахыг Эрүүл мэндийн газар (Л.Мэндбаяр)-т даалгасугай.

231011970

5. Коронавируст халдвар Ковид-19 цар тахлаар өвдсөн иргэдийн тоо нэмэгдэж эмчилгээний байр, ор дутагдалтай байгаатай холбогдуулан Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн байрыг чөлөөлж эмнэлэгийн ор дэлгэх ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар (Л.Мэндбаяр), Боловсрол, соёл урлагын газар (Мөнхцэцэг), Онцгой байдлын газар (Ж.Эрдэнэбат)-т тус тус даалгасугай.

6. Аймгийн нутаг дэвсгэрт голомт бүхий объект, албан байгууллага, орон сууцны орц хонгил, цонх, хаалга, цахилгаан шат, нийтийн тээвэр, хүүхдийн тоглоомын талбай, нийтийн эзэмшлийн зам талбай зэрэг байршилд халдваргүйжүүлэлтийн ажлыг шат дараатай зохион байгуулж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), Зооноз өвчин судлалын төв (Ц.Гэрэлмаа)-д тус тус даалгасугай.

7. Орон нутгийн хэмжээнд Коронавируст (Ковид19)-ын Дельта хувилбар бүртгэгдсэнтэй холбогдуулан халдвар хамгааллын дэглэмийг сахиж ажиллахыг иргэд болон аж ахуй нэгж байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

8. Аймгийн хэмжээнд 55-аас дээш насны иргэдийн дархлаажуулалтын 3 дахь тунг өөрсдийнх нь хүсэлтийг тулгуурлан зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар (Л.Мэндбаяр)-т даалгасугай.

9. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав), Шуурхай штабын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ